



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН
ТАЙЛАН Ч.ЗОРИГТБААТАР

Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Ч.Зоригтбаатар миний бие 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль, Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон Банкны Дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2025 оны 1 дүгээр улирал буюу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 6 удаа хуралдсан бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 1 сарын 20-ны өдрийн хурлаар

- Эрсдэлийн удирдлагын нэгдсэн тайлан /2024 оны 4 улирлын байдлаар/
- Тусгай активын нэгжийн гүйцэтгэлийн тайлан
- Чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, 2025-2029 оны төлөвлөгөө
- Зээлийн бодлого, эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд өөрчлөлт оруулах санал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 1 сарын 21-ний өдрийн хурлаар

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
- Гүйцэтгэх удирдлагын ажлын тайлан /2024 оны 4 улирал/
- Хүний нөөц, цалин урамшууллын судалгаа
- 2024 оны гүйцэтгэлийн урамшуулал олгох эсэх тухай
- Макро эдийн засгийн төлөв 2025 он
- Банкны 2025 оны бизнес төлөвлөгөө, төсвийн талаарх асуудлуудыг хэлэлцэж батлахад дэмжсэн саналтайгаар оролцсон.
- Банкны бүтэц зохион байгуулалт, орон тооны талаарх саналтай танилцаж, гүйцэтгэх захирлын шууд удирдлагад хяналт шалгалтын нэгж шинээр байгуулах, мөн комплаенсийн нэгжийг харьяалуулах саналтайгаар тус бүтэц зохион байгуулалт, орон тоо батлах асуудалд түдгэлзсэн.

- Дотоод аудитын газрын 2025 оны бүтэц, орон тоо, төсөв, ажлын төлөвлөгөө
- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх тайлан
- 2024 оны хөрөнгийн тооллогын танилцуулга
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай асуудлуудтай танилцаж, дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 сарын 21-ний өдрийн хурлаар

- Дотоод аудитын газрын мэдээллийн технологийн аудитын хэлтсийн захирлыг өөрийн гаргасан хүсэлтийн дагуу түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэхэд дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 сарын 24-ний өдрийн хурлаар

- Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох саналын тухай хэлэлцэж, Хөндлөнгийн аудитын байгууллага болох “Өлзийт экаунт аудит” ХХК-г Тээвэр хөгжлийн банкны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын үйлчилгээ үзүүлэх байгууллагаар сонгож, тус хөндлөнгийн аудитын байгууллагатай гэрээ байгуулах эрхийг банкны Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбаяр/-д олгохоор шийдвэрлэхэд дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 сарын 25-ны өдрийн хурлаар

- Тээвэр хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- Цалин шинэчлэн тогтоох тухай асуудлуудыг хэлэлцэж, тус асуудлуудад дэмжсэн саналтайгаар хуралд оролцсон.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 сарын 31-ний өдрийн хурлаар

- Компаенсийн газрын 2025 оны 1 дүгээр улирлын тайлантай танилцсан бөгөөд тус тайланг зохих журмын дагуу Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон.



Төлөөлөн удирдах зөвлөлийн дээрх хурлуудад миний бие оролцож, зохих санал дүгнэлтийг тухай бүр гаргаж, саналын зөрүүтэй асуудлуудад өөрийн байр суурийг илэрхийлэн оролцсон.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
Аудитын хорооны хуралд оролцсон байдал**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр, 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдөр тус тус хуралдсан бөгөөд тус хурлуудаар нийт 3 асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гаргасан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

Аудитын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар:

1. Банкны дотоод аудитын газрын 2024 оны ажлын тайлан танилцуулах, 2025 оны төсөв, төлөвлөгөөний саналын тухай
2. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх тайлан /2024 оны 4 дүгээр улирлын байдлаарх/

Дээрх асуудлуудыг хэлэлцэж дараах санал дүгнэлтийг гарган гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож ажилласан. Үүнд:

- Банкны дотоод аудитын газрын 2024 оны ажлын тайлантай танилцаж, 2025 оны төсөв, төлөвлөгөөг хавсралтаар батлахад дэмжсэн саналтайгаар оролцсон бөгөөд дотоод аудитын газрын 2025 оны төсөв, төлөвлөгөөг батлах асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлахаар шийдвэрлэсэн.

- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх 2024 оны 4 дүгээр улирлын байдлаарх тайлантай танилцсан.

Аудитын хорооны 2025 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар:

1. Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу хөндлөнгийн аудитын байгууллага сонгох асуудалтай танилцаж, банкны 2024 оны санхүүгийн хөндлөнгийн аудитын байгууллагаар “Өлзийт экаунт” ХХК-г сонгох саналыг дэмжиж, тус асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.



**Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их
хэмжээний хэлцлийн тайлан**

Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болохыг тэмдэглэж байна.

Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын багийн хооронд мэдээлэх процесс, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм, журмын дагуу хэвийн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар

